

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 08 сарын 19-ны өдөр

№ 22/25

Улаанбаатар хот

Төсөл хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дүгээр зүйлийн 76.1.18 дахь заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 08 сарын 19-ны өдрийн санал хураалтын үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн хэрэгжүүлэхээр төлөвлөж буй 10 сая ам.доллар хүртэлх хэмжээний төслийг хэрэгжүүлэхийг зөвшөөрсүгэй.
2. Тус төслийг удирдан хэрэгжүүлэхийн Компанийн гүйцэтгэх захирал Бүрэнмэнд овогтой Лхагвадорж-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



/Д.ДАЯНБИЛГҮҮН/

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 08 сарын 19-ны өдөр

№ 21/25

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.5 дахь заалт, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх заалт, 64 дүгээр зүйлийн 64.2 дахь заалт, 65 дугаар зүйлийн 65.1, 65.4 дэх заалт, 71 дүгээр 71.1, 71.3, 71.4 дэх заалт, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалтууд болон Санхүүгийн Зохицуулах Хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг үндэслэн компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ НЬ:**

3. “БидиСЕК ҮЦК” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2025 оны 09 сарын 30-ны өдөр 11:00 цагт Улаанбаатар хотод <https://agm.mn/> холбоосоор дамжуулан цахим хэлбэрээр хуралдуулсугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
 - а) Компанийн 2025 оны хагас жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах
 - б) Компанийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай
 - с) Давуу эрхийн хувьцаа гаргах тухай
5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 09 сарын 05-ны өдрөөр тогтоосугай.
6. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр болон компанийн цахим хуудсаар дамжуулан 2025 оны 08 сарын 21-ний өдөр нийтэд мэдээлж, уг зарыг 2025 оны 09 сарын 05-ны өдөр дахин нийтэд мэдээлсүгэй.
7. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, танилцуулга, саналын хуудас зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2025 оны 08 сарын 26-ны өдөрт багтаан үнэт цаасны брокер дилерийн компанид хүргүүлсүгэй.
8. Хурлын зарын загвар, хэлэлцэх асуудлыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
9. Хурлын дэгийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
10. Хурлын танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг гуравдугаар хавсралтаар баталсугай

11. Хурлын саналын хуудасны загварыг дөрөвдүгээр хавсралтаар баталсугай.
12. Хурлын материалыг 2025 оны 08 сарын 26-ны өдрийн дотор брокер, дилерийн компаниудад хүргүүлж, хувьцаа эзэмшигчдэд Хурлын материалтай ажлын өдрийн 10:00-17:00 цагийн хооронд танилцах боломж бүрдүүлэхийг Гүйцэтгэх захирал болон Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
13. Хуралд биечлэн оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдэд саналаа урьдчилан өгөх боломжоор хангаж Компанийн өөрийн байранд урьдчилсан саналын хуудсыг хүлээн авах ба саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацаа 2025 оны 09 сарын 29-ны өдрийн 17:00 цаг байна.
14. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зохион байгуулах комиссын даргаар Г.Энхжин, гишүүнээр Э.Пүрэвжаргал нарыг тус тус томилсугай.
15. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын даргаар Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Даянбилгүүн, тооллогын комиссын даргаар “БидиСЕК ҮЦК” ХК-ийн Хөрөнгө оруулалтын албаны захирал С.Дөлгөөн, гишүүнээр “БидиСЕК ҮЦК” ХК-ийн мэргэжилтэн Э.Мөнхсүвд нарыг тус тус томилсугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:**



/Д.ДАЯНБИЛГҮҮН/